



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-5</i>
<i>1.Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай</i>	<i>4-5</i>

***Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны
7 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 14 гишүүн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 20 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Тасалсан: Б.Жаргалан, Н.Номтойбаяр, Д.Цогтбаатар, Ж.Энхбаяр, С.Эрдэнэболд.

Нэг.Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн тавьсан асуултад хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хариулж, тайлбар хийв.

Д.Ганбат: Тусгай хяналтын дэд хороог Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан С.Бямбацогт Д.Цогтбаатар, Д.Ганбат, Р.Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 07 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГАЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ГАНБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 14 цаг 20 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Ганбат: Болормаа гишүүн, Бямбацогт гишүүн, Ганбат, Дэлгэрсайхан гишүүн, Жангабыл гишүүн, Жаргалан гишүүн, Наранбаяр гишүүн, Номтойбаяр гишүүн, Хосбаяр гишүүн, Цогтбаатар гишүүн, Энхбаяр гишүүн, Энхнасан гишүүн, Эрдэнэболд гишүүн, Эрдэнэбүрэн гишүүн, Наранбаатар гэсэн ийм гишүүд манай байнгын хороонд харьяалагдах юм байна аа.

Ингээд байнгын хорооны ирц бүрдсэн тул өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Ирц хэдтэй байна? 20 гишүүнээс 15 гишүүн ирсэн байна. Ирц хангалттай байна. Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцье ээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27.1-д Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо байгуулж болно гэж заасан байна аа.

Ингээд 22.3 дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаан Байнгын хорооны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Дэд хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална аа гэж байна.

Дэд хорооны бүрэлдэхүүнд орох гишүүний нэрсийг танилцуулъя.

Энэ өмнө байсан гишүүд юм байна. Дэлгэрсайхан гишүүн, Бямбацогт гишүүн, Цогтбаатар гишүүн ингээд МАН-аас ийм 3 гишүүн байдаг юм байна. 5 гишүүний бүрэлдэхүүнтэй. Манайхаас би байдаг юм Ганбат.

Ингээд Эрдэнэбүрэн гишүүн орох юм байна. Ийм 5 хүний бүрэлдэхүүнтэй Байнгын хороо байгуулах юм байна аа.

Дэд хорооны бүрэлдэхүүний талаар өөр саналтай гишүүд байна уу? Алтангэрэл гишүүн. Байж байгаарай өөр гишүүн байна уу? Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Асуулт байна л даа. Энэ процесс нь яаж явах ёстой юм бол? Урьд нь байсан хүмүүсийг ойлголоо. Тэгээд урьд нь байсан хүмүүсээ яг улираан гээд хоорондоо ярьчихсан юм уу гэдэг асуудал ийм асуулт байна.

Д.Ганбат: Яах вэ энэ ингэдэг л дээ. Хамгийн олон сонгогдсон гишүүн энэ Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд ордог. Бямбацогт гишүүн чинь хэд байна? Зургаа байна уу? 5, Дэлгэрсайхан гишүүн чинь 3, Цогтбаатар гишүүн чинь 4 билүү, 3 билүү. Би 3, Эрдэнэбүрэн гишүүн 2. Ингээд яг байгаа бүрэлдэхүүн нь ингэж таараад байгаа юм. Тэгээд энэ Байнгын хорооны бүрэлдэхүүнд байгаа хүнээс авдаг. Аюулгүй байдлын та аюулгүй байдалд байхгүй байна. Энхбаяр гэж байна шүү дээ. Ж.Энхбаяр юм байна. Үгүй ээ тэгээд би мэдэхгүй шүү дээ.

Цогтбаатар гишүүн, Энхбаяр гишүүн 2 солигдох байх. Тэгээд тэрийг нь тэмдэглээд үлдээчихье. Та Байнгын хороонд оронгуутаа солигдчих юм уу? Цогтбаатар гишүүн 2-ын нэг нь байх нь байна гэж ойлгоё. Тэгээд Байнгын хорооныхоо бүрэлдэхүүнийг Ардын нам өөрсдөө шийддэг юм байгаа биз ярьж

тийм ээ. Их Хурал бүлэг дээр яриад ишийдчих байх.

Өөр асуулт байхгүй юу. Ингээд санал хураалт.

Асуулт байхгүй асуултаа тасалчихъя.

Саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Ингээд төхөөрөмж ажиллахгүй байгаа юм чинь хэдүүлээ гар өргөөд ишийдчихье гэсэн горимын саналтай байна. Миний саналыг дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү? Татгалзаж байгаа гишүүн байна уу? Нэг гишүүн байна. Бусад нь дэмжсэн байна.

Ингээд Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дэлгэрсайхан гишүүн, Бямбацогт гишүүн, Цогтбаатар гишүүн, Ганбат миний бие, Эрдэнэбүрэн гишүүн энэ гишүүдийг баталъя гэсэн саналыг айн Цогтбаатар

буюу Энхбаяр тийм ингээд дэмжье гэсэн санал байгаа.

Түдгэлзсэн татгалзсан гишүүд байна уу? Алга байна. Яах вэ ингэж болно болохгүй гэсэн юм байхгүй байх ямар ч байсан би зүгээр тэмдэглүүлээд үлдээчихье. Гэхдээ та 2-ын нэг нь л байх нь байна шүү дээ тэ.

Санал хураалт 100 хувиар дэмжлээ 5 хүнийг.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныг нэг хүн дэмжээгүй юм байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье ээ.

14.27 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА